

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН  
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын хууль тогтоомж санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг тогтоох, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг Засгийн газар баталж, Улсын Их Хуралд танилцуулах, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалыг анхдагч хуулийн төсөл болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт оруулах бол заавал хийдэг байх, хуулийн төслийн танилцуулгыг товч болон дэлгэрэнгүй хэлбэрээр бэлтгэх, Монгол Улсын Их Хурлаас баталсан хуулийн албан бус орчуулгыг хууль санаачлагч хийдэг байх зэрэг зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Материаллаг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа тул хуулийн төсөл батлагдсанаар аливаа зардал үүсэхгүй гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг [D-parliament.mn](http://D-parliament.mn) цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Байнгын хороод хуулийн төсөл хэлэлцэх явцдаа Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний асуудал хөнддөг, өргөн мэдүүлээгүй байхад шинээр агентлаг байгуулдаг асуудлыг энэ хуулийн төслөөр зохицуулж байгаа эсэх, түүнчлэн хуулийн төсөлтэй холбогдуулан дагасан хуулийн төсөл боловсруулахдаа суурь хуульд зарчмын шинжтэй, үндсэн үзэл баримтлалаас өөрөөр томъёолж нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал дээр тодорхой босго тогтоох асуудлын талаар асуулт асууж, хариулт авсан болно.


Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 70 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Л.МӨНХБААТАР**